

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Мандал-овоо сумын Цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: **ӨМА-2022/38/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.umnugovi@audit.gov.mn Өмнөговь аймаг 2022 он	Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр Утас: 70533539 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn Аудитын менежер: Т.Хонгорзул Утас: 88034203 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn Аудитор: Э.Жаргал Утас: 88025452 Цахим хаяг: jargale@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022.02.23 № 138
танай _____-ны № _____-т

МАНДАЛ-ОВОО СУМЫН 17 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ш.ГЭРЭЛМАА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мандал-овоо сумын 17 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Мандал-овоо сумын 17 дугаар Цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Хүүхдийн хоолны норматив зардлыг 66.300 төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан, хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлаас 4,397.500 төгрөгийн зөөврийн компьютер, принтер худалдан авсан, орон тооны жишиг нормд батлагдаагүй ажилтан авч ажиллуулан 7,084.130 төгрөгийн цалин олгосон зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, ангилал, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага


Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

010000061

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A handwritten signature in black ink, appearing to be 'С.Цэрэнбаяр', is written over a faint red rectangular stamp.

С.ЦЭРЭНБАЯР

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	21.5	28.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	522.7	562.0
	Нийт хөрөнгийн дүн	544.2	590.1
	Нийт өр төлбөрийн дүн	-	-
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	544.2	590.1
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	544.2	590.1
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	268.0	265.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	346.7	321.9
	Үйл ажиллагааны үр дүн	(78.7)	(56.2)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	1.2
	Үйл ажиллагааны нийт үр дүн	(78.7)	(57.4)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	18.7	544.2
	Тайлант оны үр дүн	45.9	45.9
	Эцсийн үлдэгдэл	64.6	590.1
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	268.0	265.7
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	264.4	261.3
	Үйл ажиллагааны ЦМГ	3.5	4.4
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	(3.5)	(4.4)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	-
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	260.6	258.0
	Урсгал зардал	260.6	258.0
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	260.6	258.0
	Улсын төсвөөс санхүүжих	-	-
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	25.7	24.3
	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	234.9	233.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Мандал-овоо сумын Цэцэрлэг нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Багш ажилтан бүр хүүхдийг хамгаалах, хөгжүүлэх, суралцах үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг оролцоог нэмэгдүүлж, хүүхдэд ээлтэй үйлчилгээг чанартай тасралтгүй үзүүлэх боломжийг бүрдүүлж ажиллана" гэж тодорхойлсон байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" ,
- Засгийн газрын 2021 оны төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний 43 дугаар тогтоол,

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

Аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал буюу Монгол улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой дараах асуудлууд байна. Үүнд:

- Хүүхдийн хоолны зарцуулалтын нормыг 0.006 сая төгрөгөөр илүү зарцуулсан
- хичээл практикийн зардлаас 4.4 сая төгрөгөөр зөөврийн компьютер, принтер худалдан авсан
- батлагдсан төсвийн 10 хувь болох 26.0 сая төгрөг хэмнэхээс 2.6 сая төгрөг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.
- Тайлант оны 8 дугаар сараас эхлэн Д.Дүүвээг эмчээр авч ажиллуулан 7.0 сая төгрөгийн цалин олгосон байна.

Дөрөв. Аудитын гол асуудал

Мандал-овоо сумын Цэцэрлэгийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөөлөх гол асуудал байхгүй байна.

Тав. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан болно.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мандал-овоо сумын Цэцэрлэг нь

- 149 мэдээлэл байршуулахаас 16 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан
- 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа ажил үйлчилгээний 21.9 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй байна.

Зургаа. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллага нь Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-г мөрдөж ажиллаагүй төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Иймд дараагийн аудитаар горим сорил хэрэгжүүлэн анхаарч үзэх шаардлагатай гэж үзэв.

Долоо. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 57.5 төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 0.6 сая төгрөгийн алдааг залруулж, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар баталсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар", Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 албан шаардлага, Засгийн газрын 2019 оны "Хоолны зардлын норматив тогтоох тухай" 450 дугаар тогтоолын хэрэгжилттэй холбоотой 1 төлбөрийн акт тогтоолоо.

4.1 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал

1.Илрүүлэлт:

хичээл практикийн зардлаас 4.4 сая төгрөгөөр зөөврийн компьютер, принтер худалдан авсан байна.

Өгсөн албан шаардлага:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны "Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай" 190 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах

2.Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн системд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бараа ажил үйлчилгээний 21.9 сая төгрөгийн 2 мэдээллийг байршуулаагүй, 149 мэдээлэл байршуулахаас 16 мэдээллийг хугацаа хоцруулан байршуулсан байна.

Өгсөн албан шаардлага:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4.4"таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"-ыг мэдээлнэ гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

3.Илрүүлэлт:

батлагдсан төсвийн 10 хувь болох 26.0 сая төгрөг хэмнэхээс 2.6 сая төгрөг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна

Өгсөн албан шаардлага:

Цаашид төсвийн хэмнэлтийн талаар авч байгаа арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах

4.Илрүүлэлт:

Тайлант оны 8 дугаар сараас эхлэн Д.Дүүвээг эмчээр авч ажиллуулан 7.0 сая төгрөгийн цалин олгосон байна.

Өгсөн албан шаардлага:

БСШУСС,Сангийн сайдын хамтарсан 2018 оны А/817/287 тушаал "Хүүхдийн цэцэрлэгийн захиргаа үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн норматив"-ыг хэрэгжүүлж ажиллах

4.1 Төлбөрийн акт

1.Илрүүлэлт:

Хүүхдийн хоолны зарцуулалтын тооцооллыг тулган баталгаажуулахад 0.006 сая төгрөгөөр илүү зарцуулсан байна

3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	Дүн	3	45,3	0	0	0	0	1	45,3	0	0
	НИЙТ ДҮН	8	57,5	2	0,6	1	0,06	2	56,9	0	0